...хоног тутмын хэвлэл
...ы 05 дугаар сарын 11
№18 /687/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

...гол Улсын Их
...алын тогтоол

818

...онгол Улсын
...нхийлөгчийн
зарлиг

821

...онгол Улсын
...сгийн газрын
тогтоол

833

## Хуулийн төсөл буцаах тухай

## Төрийн захиргааны зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай

## "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг батлах тухай

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

188. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 16 818

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

189. Орон тооны бус шинжээч томилох тухай Дугаар 77 818

190. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний үүрэг дэв олгох тухай Дугаар 78 821

191. Төрийн захиргааны зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 79 821

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

192. Цогц хөтөлбөр батлах тухай Дугаар 32 823

193. Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай Дугаар 34 832

194. Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай Дугаар 35 833

195. "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг батлах тухай Дугаар 36 833

196. Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай Дугаар 37 850

197. Журам батлах тухай Дугаар 38 851

198. Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэх тухай Дугаар 41 854

199. Аргачлал батлах тухай Дугаар 48 854

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

**Орон тооны бус шинжээч томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн орон тооны бус шинжээчээр Лувсангомбын Моломжамц, Цэрэнпилийн Гомбосүрэн, Баянмөнхийн Билэгт, Загдсүрэнгийн Болдбаатар, Дашийн Бямбасүрэн, Найдансүрэнгийн Золжаргал, Гомбын Цогтсайхан, Баянтөрийн Бат-Очир, Ойдовын Чулуун, Болдын Бадрал, Лувсандоржийн Сүхбуян, Базарсадын Алтан-Очир, Рагзэнгийн Бат-Эрдэнэ, Жүгнээгийн Амарсанаа, Шагдарын Болдбаатар, Пагважавын Нямдаваа, Жамъянгийн Батсуурь, Чүлтэмдоржийн Тунгалаг, Баасандоржийн Батзаяа, Рэнчингийн

Мижиддорж, Тогтууны Хаптар, Шаравын Бат-Эрдэнэ нарыг тус тус томилсугай.

2. Орон тооны бус шинжээчдийн хариуцан ажиллах чиглэлийг хавсралтаар батлсугай.

3. Энэхүү зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 64, 85, 2010 оны 22, 23, 217 дугаар зарлиг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 05 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 77 дугаар зарлигийн хавсралт

## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧДИЙН ХАРИУЦАХ АЖЛЫН ЧИГЛЭЛ

| д/д | Нэрс | Эрдмийн зэрэг цол, албан тушаал | Хариуцах чиглэл |
|---|---|---|---|
| | *Нэг. Оршин тогтнохын аюулгүй байдлын чиглэлээр* | | |
| 1 | Лувсангомбын Моломжамц | Цэргийн шинжлэх ухааны доктор, дэслэгч генерал | Батлан хамгаалах бодлогын асуудал |
| 2 | Цэрэнпилийн Гомбосүрэн | Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд | Гадаад бодлогын асуудал |
| 3 | Баянмөнхийн Билэгт | Тагнуулын ерөнхий газрын дарга асан | Тусгай албадын асуудал |
| 4 | Загдсүрэнгийн Болдбаатар | Боловсролын доктор | Зэвсэгт хүчний асуудал |
| | *Хоёр. Эдийн засгийн аюулгүй байдлын чиглэлээр* | | |
| 5 | Дашийн Бямбасүрэн | Эдийн засгийн ухааны доктор | Эдийн засгийн асуудал |
| 6 | Найдансүрэнгийн Золжаргал | Монгол банкны дэд ерөнхийлөгч | Банк санхүүгийн асуудал |
| 7 | Гомбын Цогтсайхан | Эдийн засгийн ухааны доктор | Эдийн засгийн асуудал |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Баянтэрийн Бат-Очир | Боловсролын доктор, Монгол Улсын Уул уурхайн зөвлөх инженер | Уул уурхайн асуудал |
| 9 | Ойдовын Чулуун | Боловсролын доктор | Ураны асуудал |
| 10 | Болдын Бадрал | Боловсролын доктор | Эрчим хүчний асуудал |
| 11 | Лувсандоржийн Сүхбуян | Боловсролын доктор | Газрын тосны асуудал |
| 12 | Базарсадын Алтан-Очир | Геофизик инженер | Геологийн асуудал |
| 13 | Рэгзэнгийн Бат-Эрдэнэ | Боловсролын доктор | Боловсролын асуудал |
| *Гурав. Дотоодын аюулгүй байдлын чиглэлээр* | | | |
| 14 | Жүгнээгийн Амарсанаа | Шинжлэх ухааны доктор, Академич | Үндсэн хуульт байгууллыг бэхжүүлэх асуудал |
| 15 | Шагдарын Болдбаатар | Боловсролын доктор | Гамшиг, онцгой байдлын асуудал |
| *Дөрөв. Хүний аюулгүй байдал* | | | |
| 16 | Пагважавын Нямдаваа | Шинжлэх ухааны доктор, Академич | Эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудал |
| 17 | Жамъянгийн Батсуурь | Шинжлэх ухааны доктор | Хүн амын удмын сангийн асуудал |
| 18 | Чултэмдоржийн Тунгалаг | Шинжлэх ухааны доктор | Хөдөө аж ахуйн асуудал |
| 19 | Баасандоржийн Батзаяа | Багш дасгалжуулагч, Удирдахуйн ухааны магистр | Нийтийн биеийн тамирын асуудал |
| *Тав. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал* | | | |
| 20 | Рэнчингийн Мижиддорж | Боловсролын доктор | Хүрээлэн байгаа орчны асуудал |
| *Зургаа. Мэдээллийн аюулгүй байдал* | | | |
| 21 | Тогтуугийн Халтар | Боловсролын доктор | Мэдээллийн бүрэн бүтэн байдал, Мэдээллийн нууцлалын асуудал |
| 22 | Шаравын Бат-Эрдэнэ | Боловсролын доктор | Мэдээллийн хүртээмжтэй байдлын асуудал |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зэрэг дэв олгох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Төрийн албаны тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 2001 оны 50 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Жамсрангийн Бямбадорж, гишүүн Пүрэвийн Оюунчимэг нарт "Тэргүүн түшээ" зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 79 | Улаанбаатар хот

**Төрийн захиргааны зарим албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны
79 дүгээр зарлигийн хавсралт

## ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД

| № | Овог, нэр | Эрхэлж буй ажил | Албан тушаалын зэрэглэл | Олгох зэрэг дэв |
|---|---|---|---|---|
| 1 | Дорждамбын Зумбэрэлхам | Төрийн албаны зөвлөлийн дарга | ТӨ-YA | Тэргүүн зэрэг |
| 2 | Дашбалын Батбаяр | Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн | ТӨ-YA | Тэргүүн зэрэг |
| 3 | Гунгаагийн Баясгалан | Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | ТЗ-14 | Тэргүүн зэрэг |
| 4 | Чойнжуурын Дашням | Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга | АА-1 | Дөтгөөр зэрэг |
| 5 | Дэмбэрэлсүрэнгийн Түвшинтөр | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн дарга | АА-2 | Дөтгөөр зэрэг |
| 6 | Буянхүүгийн Доньжчимбуу | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргааны хэлтсийн дарга | АА-2 | Дөтгөөр зэрэг |
| 7 | Батжаргалын Бадамцэцэг | Үндэсний статистикийн хорооны Макро эдийн засгийн статистикийн газрын дарга | АА-3 | Дөтгөөр зэрэг |
| 8 | Бидэръяагийн Цэрэнханд | Үндэсний статистикийн хорооны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга | АА-3 | Дөтгөөр зэрэг |
| 9 | Дандарын Оюунчимэг | Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга | АА-3 | Дөтгөөр зэрэг |
| 10 | Аюушийн Дэмбэрэл | Үндэсний статистикийн хорооны Шинжилгээ, судалгааны газрын дарга | АА-3 | Дөтгөөр зэрэг |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 32 | Улаанбаатар хот

**Цогц хөтөлбөр батлах тухай**

"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2009 оны 95 дугаар тогтоолын 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор батлагсугай.

2. Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хамтран баталж, хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

3. Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсвийнхөө багцад болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хандивлагч байгууллагын хөтөлбөр, төсөлд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цогц хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дунд хугацааны үнэлгээний тайланг 2015 онд, эцсийн үнэлгээний тайланг 2020 онд багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 124 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** — **С.ЛАМБАА**

**Засгийн газрын 2011 оны 32 дугаар тогтоолын хавсралт**

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүн төрөлхтний амьдралын хэв маягийн өөрчлөлт, мэдээлэл, техник, технологийн хөгжлөөс шалтгаалан хөдөлгөөний хомсдол нэмэгдэн

хүний бие бялдрын хөгжлийн үзүүлэлт буурч, спортоор хичээллэгч хүүхэд, залуучуудын тоо цөөрч байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, Олон улсын олимпийн хороо хүлээн зөвшөөрч, төр, засгийн удирдлагуудад хүн ам биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл аж төрөх арга барил, зан үйлийг төлөвшүүлэх замаар хүний хөгжлийг сайжруулахад анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Монгол Улсын төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд анхаарч нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйлс болгох талаар арга хэмжээ авч байгаа болович хүн амын бие бялдрын соёл, эрүүл аж төрөх хэв маягийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Хүн амын дунд биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлага нэмэгдэж байна.

2009 онд хийсэн судалгаагаар хүүхэд, өсвөр үеийнхний 69.8 хувь нь бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн хувьд тухайн насныхаа бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн дундаж түвшинд хүрэхгүй, хүн амын 39.8 хувь нь илүүдэл жинтэй, хүн амын дөнгөж гуравны нэг нь өдөр тутам дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг, цэргийн албанд татагдаж байгаа залуучуудын 44.8 хувь нь эрүүл мэндийн байдлын улмаас цэргийн албанд тэнцэхгүй дүн гарсан болно. Мөн хүн амын нас баралт, өвчлөлийн шалтгаанд хүний амьдралын хэв маяг, зан үйлтэй холбоотой халдварт бус өвчин давамгайлж хүн амын амьдралын чанар, дундаж наслалтад сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд хүн ам, ялангуяа хүүхэд, залуучуудын дунд биеийн тамир, спортоор хичээллэх сонирхол нэмэгдэж, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн талаар хамт олон, албан байгууллагаас тодорхой санаачилга өрнүүлж байгаа зэрэг ахиц байгаа болович биеийн тамир, спортын салбарт тулгамдсан олон асуудал байна.

Биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээний зардлын дөнгөж 4.5 хувийг нийтийн биеийн тамирын арга хэмжээнд зарцуулдаг, 10000 хүн амд спортын 3 заал буюу 800-1000 $м^2$, нэг хүнд 22 $см^2$ талбай ногдож байгаа зэрэг нь хангалтгүй үзүүлэлт юм.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар

дэвшүүлсэн зорилтыг тусган хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахад чиглэсэн "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр" /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг боловсруулав.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа, санхүүжилт

2.1. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын хөгжлийн түвшинг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг тодорхойлж байна:

2.2.1. биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, дундаж наслалтыг нэмэгдүүлэх;

2.2.2. тамирчдын спортын амжилтыг дэлхийн түвшинд хүргэх, залгамж халааг бэлтгэх;

2.2.3. биеийн тамир, спортын салбарт төрийн болон төрийн бус байгууллагын зохистой түншлэл, хүний нөөцийн удирдлага, салбар хоорондын уялдаа холбоо, төлөвлөлтийг сайжруулах;

2.2.4. биеийн тамир, спортын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2020 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

| | |
|---|---|
| I үе шат | 2011-2015 он; |
| II үе шат | 2016-2020 он. |

2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.4.1. улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

2.4.2. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;

2.4.3. гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

2.4.4. олон улсын байгууллага, хандивлагч орны хөнгөлөлттэй зээл, тусламж;

2.4.5. бусад эх үүсвэр.

Гурав: Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх
үйл ажиллагаа, хүрэх үр дүн

3.1. Биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, дундаж наслалтыг нэмэгдүүлэх 1 дүгээр зорилтын хүрээнд:

1. иргэд, байгууллага, хамт олон амралт, чөлөөт цагаараа биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, биеийн тамир, спортын арга хэмжээ зохиох, сумын цэнгэлдэх хүрээлэн, соёл-спортын төв, аймаг, дүүргийн спортын ордонг өргөтгөн шинэчлэх;

2. аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны оршин суугчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар, ногоон байгууламж бүхий гүйлт, алхалтын зам, талбай, спорт заал, байгалийн болон хиймэл цас, мөсөн талбай байгуулж ашиглалтыг сайжруулах;

3. өмчийн бүх хэлбэрийн үйлдвэр, аж ахуйн нэгж болон байгууллагын биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн тамир, спортын арга хэмжээнд төсвийн тодорхой хувийг зарцуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4. биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээг архи, тамхи, мансууруулах бодис, сэргээш /допинг/-тэй тэмцэх, сэргийлэх сургалт, сурталчилгааны гол хэрэгсэл болгох;

5. нийтийн биеийн тамирын орон тооны арга зүйч, биеийн тамирын багш нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлж, давтан сургах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

6. биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил үйлчилгээ явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллагын үйл ажиллагааны түвшин, чанарт магадлан итгэмжлэл явуулж, эрүүл мэндийн даатгалд хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

7. ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөр, арга зүйг хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх, хичээлийн болон хичээлээс гадуурх сургалтын хүрээнд сурагч, оюутан биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг өргөжүүлэх;

8. их, дээд сургууль, коллежийн оюутан, суралцагчид спортоор хичээллэх орчин нөхцөлийг хангах, спорт-клубийн тогтолцоог нэвтрүүлэх;

9. орон сууц болон гэр хороолол, амралт, сувиллын газар, хүүхдийн зуслан зэрэг хүн ам төвлөрсөн газарт хүүхэд, залуучуудын дунд зохиох нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг өргөжүүлэх;

10. биеийн тамир, спортын талаарх хүн амын ойлголт, хандлагыг дээшлүүлэх, сонирхлыг төрүүлж, спортоор хичээллэх сонголт хийх, авьяасаа хөгжүүлэхэд чиглэгдсэн төрийн бус байгууллагын ажлыг дэмжин урамшуулах;

11. монгол хүний бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд чөлөөтэй ашиглах, мэдээлэл авах боломж бий болгох;

12. хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлог зэрэгт нийцсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх, энэ талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чанар, хүртээмжийг сайжруулах;

13. багаасаа бие бялдраа хөгжүүлэх, эрүүл мэндээ дээдлэх талаар аргачлал, хэм хэмжээ боловсруулан монгол хүүхэд бүрт тарааж нийтийн хүртээл болгох;

14. биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг сайн зохион байгуулсан, биеийн тамир, спортын салбарт хөрөнгө оруулалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, алдаршуулах;

15. биеийн тамир, спортоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

16. бүсийн төв, аймаг, хотын хүн амд зориулсан спортын амралт, аяллын бүсийг орон нутгийн онцлог, дэд бүтцэд нийцүүлэн шинээр байгуулан тохижуулах, спортын төрөл бүрийн аялал, жуулчлалыг дэмжих;

17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа анги, байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмд төлөвшүүлэх зорилгоор биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бий болгох.

Хүрэх үр дүн:

Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдэж, спортоор хичээллэгч, эрүүл мэндээ бэхжүүлэгч иргэдийн тоо өсөж, халдварт бус өвчний өвчлөл буурах хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.

Биеийн тамир, спортын салбарт магадлан итгэмжлэл нэвтэрч, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг иргэдэд стандартын дагуу үзүүлдэг болно.

3.2. Тамирчдын спортын амжилтыг дэлхийн түвшинд хүргэх, залгамж халааг бэлтгэх 2 дугаар зорилтын хүрээнд:

1. тив, дэлхийн хэмжээнд медалийн төлөө өрсөлдөх тамирчдын залгамж халаа бэлтгэх, спортын сургалт-дасгалжуулалтын тогтолцоог орчин үеийн шинжлэх ухаан, спортын анагаах ухаан, технологийн ололтод тулгуурлан хөгжүүлэх;

2. "Биеийн тамир, спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааны үндэсний төв" байгуулах;

3. тамирчдын бэлтгэлийн түвшинг олон улсын жишигт хүргэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор гадаадын өндөр зэрэглэлийн тамирчидтай хамтарсан бэлтгэл хийх ажлыг өргөжүүлэх;

4. тамирчид, дасгалжуулагчдын ёс зүйн асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусган мөрдүүлэх;

5. аймаг, нийслэлд спортын мэргэжлийн, гүнзгийрүүлсэн сургууль байгуулах ажлыг өргөжүүлэх;

6. олимп, тивийн наадамд оролцох спортын төрлийг нэмэгдүүлэх;

7. өсвөрийн, оюутны, залуучуудын, насанд хүрэгчдийн шигшээ багийн дасгалжуулагчдыг төгсөлтийн дараахь сургалтад ээлж дараалалтай хамруулах.

Хүрэх үр дүн:

Тив, дэлхийн чанартай тэмцээнд оролцсон тамирчдын амжилт өсч, тив, олимпийн наадамд эрх авсан спортын төрөл нэмэгдэнэ.

Тамирчдын спортын амжилтыг ахиулахад эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааны ололт, судалгаа, техник технологийг нэвтрүүлсэн байна.

3.3. Биеийн тамир, спортын салбарт төрийн болон төрийн бус байгууллагын зохистой түншлэл, хүний нөөцийн удирдлага, салбар хоорондын уялдаа холбоо, төлөвлөлтийг сайжруулах 3 дугаар зорилтын хүрээнд:

1. Засгийн газрын чиг үүрэгт хамаарах зарим ажил, үйлчилгээг биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагаар захиалга болон гэрээгээр гүйцэтгүүлэх, тэдний үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

2. эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн тодорхой хувийг биеийн тамир, спортын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах талаар санал боловсруулах;

3. биеийн тамир, спортыг дэмжигч бизнесийн байгууллагуудын дэмжлэгийг авах замаар салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг судлах;

4. биеийн тамир, спортын тоног төхөөрөмж, хэрэглэл, материалыг импортоор оруулах, дотоодод үйлдвэрлэх асуудлыг татварын бодлогоор дэмжих механизмыг судлах;

5. биеийн тамир, спортын салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

6. биеийн тамирын багш, дасгалжуулагч, спортын эмч, илээч нарыг Сургалтын төрийн сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах;

7. биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, багш, арга зүйчийг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах нөхцөл бүрдүүлэх;

8. биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн бус байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжих, тэдгээрийн ажил, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулах;

9. биеийн тамир, спортын байгууллагын заал, талбай, хэрэглэл, материалын стандартыг шинэчлэх;

10. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заал, гадна талбайн тохижилт, түүний стандартыг шинэчлэн орчин үеийн шаардлагад нийцүүлэх, ашиглалтыг сайжруулах.

Хүрэх үр дүн:

Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо нэмэгдэж, салбарын боловсон хүчний сургалт тасралтгүй явагдана.

3.4. Биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх 4 дүгээр зорилтын хүрээнд:

1. спортын шинэ ордны орчимд үндэсний шигшээ багийн болон бусад тамирчид байрлах, бэлтгэл хийх Тамирчдын хотхон, Өвлийн спортын ордон, "Үндэсний цэнгэлдэх хүрээлэн" цогцолбор барьж байгуулах;

2. тив, дэлхийн чанартай тэмцээнийг эх орондоо зохион байгуулах, иргэд биеийн тамираар хичээллэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор нийслэлийн дүүрэг бүрийг спортын ордон, усан бассейнтай болгох;

3. биеийн тамирын заалгүй бүх шатны сургуулийг стандартад нийцсэн биеийн тамирын заалтай болгох, холбогдох тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, ерөнхий боловсролын сургууль бүрийг биеийн тамирын зориулалтын ил талбайтай болгох;

4. орон сууцны хороолол, сургууль, цэцэрлэг, барилга байгууламж шинээр барих зөвшөөрөл олгох, зураг төсөл батлахдаа нийтийн эзэмшлийн биеийн тамирын талбай, спортын танхимыг заавал оруулдаг болох, түүнд тавих хяналтыг сайжруулах;

5. үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэлд хэрэглэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах;

6. спортын заал, талбай, чийрэгжүүлэлтийн танхим, зориулалтын зам, талбай барьж байгуулах талаар аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг өрнүүлэх, дэмжих;

7. нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн зориулалтыг өөрчлөх, шилжүүлэх, худалдахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх.

Хүрэх үр дүн:

Биеийн тамир, спортын салбар нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн ордон, цэнгэлдэх хүрээлэнтэй болж, эх орондоо тив, дэлхий, олон улсын хэмжээний спортын арга хэмжээг зохион байгуулах боломж бүрдэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага,

зохицуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх үйл ажиллагааг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

4.2. Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах асуудлыг бүх шатны Засаг дарга нар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон Биеийн тамир, спортын газар бусад мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин, 2010 оны байдлаар (%, тоо) | Хүрэх үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|---|
| | | | 2015 он | 2020 он |
| 1. | хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын хувь | 23.0 | 28.0 | 33.0 |
| 2. | долоо хоногт 2-3 удаа 30 минутаас доошгүй хугацаагаар дунд зэргийн идэвхтэй хөдөлгөөнийг тогтмол хийдэг хүний эзлэх хувь | 18.6 | 23.6 | 28.6 |
| 3. | илүүдэл жинтэй хүний эзлэх хувийн жин /Биеийн жингийн индекс-БЖИ ≥ 25кг/м²/ | 39.8 | 30.8 | 25.0 |
| 4. | биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн хувь | 17.4 | 30.0 | 46.0 |
| 5. | спортоор хичээллэгчдийн хувь | 5.0 | 30.0 | 45.0 |
| 6. | биеийн тамир, спортын арга хэмжээнд зориулан улсын төсвөөс зарцуулж байгаа нийт хөрөнгийн хэмжээнд нийтийн биеийн тамирт зарцуулж буй хөрөнгийн эзлэх хувь | 4.5 | 10 | 20 |
| 7. | биеийн тамир, чийрэгжүүлэлтийн орон тооны арга зүйч | 62 | 90 | 120 |
| 8. | биеийн тамир, чийрэгжүүлэлтийн байгууллага | 85 | 110 | 130 |
| 9. | байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх биеийн тамир, спортын хамтлаг | 650 | 700 | 800 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. | магадлан итгэмжлэлд хамрагдсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн байгууллага | 0 | 20 | 40 |
| 11. | спортын дунд сургууль | 6 | 15 | 24 |
| 12. | биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр батлагдсан стандарт | 3 | 10 | 15 |
| 13. | спортын цогцолбор | 1 | 8 | 10 |
| 14. | спортын ордон | 33 | 43 | 53 |
| 15. | цэнгэлдэх хүрээлэн | 311 | 320 | 335 |
| 16. | биеийн тамир, спортын заал, талбай | 655 | 670 | 690 |
| 17. | усан бассейн | 6 | 12 | 29 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 34 — Улаанбаатар хот

**Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай**

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2011 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

| № | Хилийн боомтын нэр | Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр) | | |
|---|---|---|---|---|
| | | Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ) | | Дизелийн түлш |
| | | 90 хүртэл | 90 болон түүнээс дээш | |
| 1 | Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2 | Ханх, Ульханмайхан | 0.0 | 0.0 | 0.0 |
| 3 | Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг | 160.000 | 230.000 | 0.0 |

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 317 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД Д.ЗОРИГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 35 — Улаанбаатар хот

### Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай

Татварын ерөнхий хуулийн 60.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй болон татварын алба, татварын улсын байцаагчийн буруугаар татвар төлөгчөөс үндэслэлгүй, илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.056 хувь байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 361 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД

САНГИЙН САЙД С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 36 — Улаанбаатар хот

### "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг батлах тухай

"Хувийн хэвшлийн хөгжлийн стратеги боловсруулж хэрэгжүүлэх чиглэл өгөх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 49 дүгээр

зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.10.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг 1 дүгээр хавсралт, уг стратегийн I үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /Ч.Хашчулуун/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-д тусгасан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах үүргийг Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо"-нд хариуцуулсугай.

4. "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо"-ны бүрэлдэхүүн болон дүрмийг шинэчлэн батлахыг тус хорооны дарга, Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд жил бүрийн I улиралд багтаан танилцуулж байхыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /Ч.Хашчулуун/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ**
**ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2011 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод: "Зах зээлийн эдийн засгийн зарчим, шударга өрсөлдөөнд суурилсан хувийн хэвшил нь Монгол Улсын үндэсний хөгжилд, түүний дотор ажлын байр шинээр бий болгож, ядуурлаас гаргахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Хувийн хэвшлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг арилгах, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх үүргийг төр хүлээнэ." гэж,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 49 дүгээр зарлигт "Хувийн хэвшлийн хөгжлийн стратегийн баримт бичгийг хувийн хэвшлийн төлөөлөл, олон улсын байгууллагатай хамтран боловсруулсугай." гэж,

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.10.1-д "Хувийн хэвшлийн хөгжлийн стратегийн баримт бичгийг батлуулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна." гэж тус тус заасан нь энэхүү стратегийг боловсруулах үндэслэл болно.

Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих практик шаардлага

Монгол Улсын хэмжээнд 2010 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 68 мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 40 мянга орчим аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж нь сүүлийн 4 жилийн байдлаар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64,4-71,9 хувийг бүрдүүлж байна.

Татварын нийт орлогын 30 орчим хувийг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар эзэлж, ажиллах хүчний 70 гаруй хувь буюу 800 мянга гаруй хүн хувийн хэвшлийн салбарт ажиллаж байгаа нь ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад хувийн хэвшил томоохон үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна.

Дэлхийн банк 2004 оноос эхлэн жил бүр "Бизнес эрхлэх нь" тайланг гаргаж ирсэн. Уг тайланд дэлхийн улс орнууд дахь бизнес эрхлэх орчны нөхцөл байдал, бизнест үзүүлж байгаа төрийн үйлчилгээний хүндрэл бэрхшээл зэргийг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг байна. Монгол

Улс бизнесийн таатай орчныг үнэлэх үзүүлэлтээр 2009 онд 181 орноос 58-д, 2010 онд 183 орноос 60-д, 2011 оны тайланд 183 орноос 73-т тус тус оржээ.

Үүнд ээлжих нөхцөл таатай бус, хугацаа богино, хүү өндөр, төрийн зүгээс бизнест үзүүлэх үйлчилгээ ил тод бус, зөвшөөрөл, лиценз авахад олон шат дамжлагатай, төр, хувийн өмчийн ээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсээгүй, санхүүжилтийн олон хэлбэрийн эх үүсвэрийг бий болгох эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй зэрэг сөрөг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Түүнчлэн хувийн хэвшлийн хөгжил, үйл ажиллагааг зохицуулах төрийн бодлого, шийдвэрт тэдний санал, санаачилга, зөвлөмжийг тусгах арга механизм төлөвшөөгүй, төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээнд хувийн хэвшлийн оролцоо, үүрэг, хариуцлага бага, төр, хувийн хэвшлийн хооронд мэдээлэл солилцох ил тод байдал бүрдээгүй зэрэг нь хувийн хэвшлийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Иймд хувийн хэвшлийн бизнес эрхлэх орчныг боловсронгуй болгох, санхүүжилт авах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох шаардлагатай байгаа бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад бизнес эрхлэгчдийн чадавхи, нөөц боломжоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийг (цаашид "Стратеги" гэх) боловсруулав.

Хоёр. Стратегийн зорилго, зорилт

2.1. Стратегийн зорилго

"Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-ийн зорилго нь Монгол Улсад бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг харилцан ашигтайгаар хөгжүүлэх, ажлын байр, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Стратегийн зорилгыг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх.

Зорилт 2. Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засаг, санхүү, хөрөнгө

оруулалт, гадаад худалдааны бодлогоор дэмжих.

Зорилт 3. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох.

Зорилт 4. Хувийн хэвшлийн хөгжлийг хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалт, хүний нөөцийн бодлогоор дэмжих.

Гурав. Стратегийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт

3.1. Стратегийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах;

3.1.2. бизнесийн шударга өрсөлдөөн, эрх тэгш байдлыг хангах;

3.1.3. хувийн хэвшлийн идэвх санаачилгад тулгуурлан ил тод, ажил хэрэгчээр хамтран ажиллах.

3.2. Нэр томъёоны тодорхойлолт:

3.2.1. төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа гэдэг нь дунд болон урт хугацааны хөгжлийн стратеги, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа бодлогын баримт бичиг боловсруулах, түүнийг сайжруулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, түншлэх үйл ажиллагааг хэлнэ;

3.2.2. төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг нь төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн болон дэд бүтцийн салбарын суурь үйлчилгээг гэрээний үндсэн дээр шаардлагатай нөөц (ноу-хау, хөрөнгө оруулалт, хүний нөөц, менежмент)-ийг ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, учирч болох эрсдэлийг талууд зохих хувь хэмжээгээр хүлээх үйл ажиллагааг хэлнэ.

Дөрөв. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Зорилт 1. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр:

4.1.1. хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих зорилгоор шаардлагатай эрх зүйн шинэ баримт бичгийг боловсруулах, холбогдох

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.1.2. бизнес эрхлэхэд хүндрэл, чирэгдэл учруулж байгаа баримт бичгийг (журам, тушаал, шийдвэр, тусгай зөвшөөрөл, лиценз г.м) хүчингүй болгох, тоог цөөлөх арга хэмжээ авах;

4.1.3. хөрөнгө, санхүүгийн зах зээлийг боловсронгуй болгох эрх зүйн таатай орчныг бий болгох;

4.1.4. бизнес, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой дагаж мөрдөж байгаа стандартуудыг хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих шаардлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулах, олон улсын дэвшилтэт стандартыг нэвтрүүлэх;

4.1.5. ногоон эдийн засаг, ногоон бизнесийн хөгжлийг дэмжих талаар эрх зүйн шинэ баримт бичиг боловсруулах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах.

4.2. Зорилт 2. Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны бодлогоор дэмжих чиглэлээр:

4.2.1. стратегийн ач холбогдолтой болон тэргүүлэх чиглэлийн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.2. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлийн хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх;

4.2.3. хувийн хэвшлийн зүгээс Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нэмүү өртөг бий болгоход чиглэсэн томоохон санал болгосон төслүүдийг Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх;

4.2.4. бизнесийн үйл ажиллагааны санхүү, зээлийн орчныг сайжруулах бодлогыг уялдуулан шаардлагатай баримт бичгийг боловсруулах;

4.2.5. бизнесийн эрсдэлийг бууруулах зорилгоор давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлэх;

4.2.6. хувийн хэвшил дэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад худалдааг хөнгөвчлөн өртөг, зардлыг бууруулах;

4.2.7. бүсийн тулгуур төвүүдэд хөдөө аж ахуйн түүхий

эдэд суурилсан, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн парк, жижиг, дунд үйлдвэрүүд байгуулах.

4.3. Зорилт 3. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох чиглэлээр:

4.3.1. бизнес эрхлэгчид, хувийн хэвшилд үзүүлэх төрийн үйлчилгээг ил тод, ойлгомжтой болгох;

4.3.2. төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийт, бизнес эрхлэгчдэд шуурхай хүргэх сүлжээ, бүтцийг бий болгох;

4.3.3. Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах;

4.3.4. Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын зүгээс хэрэгжүүлэх бизнес эрхлэхтэй холбоотой аливаа бодлого, шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулахдаа хувийн хэвшил, тэдний эрх бүхий төлөөллийн байгууллага, мэргэжлийн холбоодын санал зөвлөмжийг авч тусгадаг байх механизмыг бий болгож хэрэгжилтийг ханган ажиллах;

4.3.5. бизнес инкубатор, бизнес зуучлал, бизнес зөвлөгөө болон сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.6. бизнесийн орчны талаархи судалгаа, бизнес эрхлэгчдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

4.3.7. хувийн хэвшлээс санаачлан боловсруулсан бизнесийн орчныг сайжруулах төсөл, хөтөлбөрийг гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагад танилцуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;

4.3.8. тухайн салбарыг төлөөлөх эрх бүхий санхүүгийн болон хүний нөөцийн чадавхитай мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, тэдгээрийн нэгдэлд төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх.

4.4. Зорилт 4. Хувийн хэвшлийн хөгжлийг хөдөлмөр эрхлэлт,

мэргэжлийн боловсрол, сургалт, хүний нөөцийн бодлогоор дэмжих чиглэлээр:

4.4.1. хувийн хэвшлийн салбарт мэргэжлийн зэрэг дэв олгодог тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх;

4.4.2. хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх асуудлаар холбогдох яам, их, дээд сургууль хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.4.3. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг эрх зүй, татвар, санхүүгийн чиглэлээр сургах, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Тав. Стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах нь

5.1. Стратегид тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо" хэрэгжүүлнэ.

5.2. "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо"-ны ажиллах журмыг хорооны дарга батлаж, тус хорооноос хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнгийн талаар жил бүр Засгийн газарт танилцуулж, үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллана.

5.3. "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо"-ны ажлын албаны үүргийг үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран гүйцэтгэнэ.

5.4. "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо" нь дараах чиглэлээр орон тооны бус салбар зөвлөлийг байгуулан ажиллуулж болно:

5.4.1. жижиг, дунд бизнес;

5.4.2. уул уурхай, аж үйлдвэр;

5.4.3. барилга, дэд бүтэц;

5.4.4. байгаль орчин, аялал жуулчлал;

5.4.5. хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр;

5.4.6. эрүүл мэнд;

5.4.7. боловсрол, соёл;

5.4.8. хөдөлмөр эрхлэлт, хүний нөөц;

5.4.9. банк, санхүү;

5.4.10. худалдаа, хөрөнгө оруулалт;

5.4.11. орон нутгийн бизнесийн хөгжил.

5.5. Холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл нь дээр дурдсан чиглэлээр орон тооны бус салбар зөвлөл байгуулан ажиллуулж болно.

5.6. Орон тооны бус салбар зөвлөлд тухайн салбарыг төлөөлөх эрх бүхий мэргэжлийн холбоо, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, судалгааны байгууллагын төлөөлөл орж ажиллана. Салбар зөвлөл нь тухайн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлыг судалгааны үндсэн дээр гарган тавьж, шийдвэрлэх арга замын талаар санал, зөвлөмж гаргана.

5.7. Орон тооны бус салбар зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо" батална.

Зургаа. Хэрэгжүүлэх үе шат

6.1. Стратегийн дараахь хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат - 2011-2013 он
Хоёрдугаар үе шат - 2014-2016 он.

Долоо. Санхүүжилт

7.1. Стратегийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

7.1.1. улс, орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламж, хандив;

7.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө;

7.1.4. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

7.1.5. хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

Найм. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

8.1. Стратегийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

8.1.1. хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин боловсронгуй болсон байна;

8.1.2. хувийн хэвшлийн тогтвортой хөгжлийг дэмжих эдийн засаг, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдсэн байна;

8.1.3. дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх хувийн хэвшлийн оролцоо, хувь хэмжээ нэмэгдсэн байна;

8.1.4. бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн хувьд хөрөнгө, санхүүгийн олон эх үүсвэр бий болж, зээлийн орчин, нөхцөл сайжирна;

8.1.5. бизнес эрхлэхэд тавигдах шаардлагагүй тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лиценз, дүрэм, журмын тоо тодорхой хувиар цөөрсөн байна;

8.1.6. экспортын бүтээгдэхүүний нэр төрөл олширч, экспортын хэмжээ нэмэгдэнэ;

8.1.7. төрийн үйлчилгээ илүү ил тод, шуурхай, ойлгомжтой болно;

8.1.8. төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа ил тод, тунгалаг зарчмын дагуу явагдаж сайжирна;

8.1.9. Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагын бодлого, шийдвэрт хувийн хэвшлийн санал, зөвлөмж тусгагддаг болно;

8.1.10. төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийг төлөөлөх эрх, чадвар бүхий мэргэжлийн холбоод хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

8.2. Стратегийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

8.2.1. шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн тоо;

8.2.2. дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эзлэх хувийн хэвшлийн оролцоо, хувь хэмжээ 65 хувиас доошгүй байх;

8.2.3. хувийн хэвшилд арилжааны банкнаас бусад санхүүгийн эх үүсвэрээс олгосон зээл, хөрөнгө оруулалтын хэмжээ нийт хөрөнгө оруулалтын 20-иос доошгүй хувийг эзэлж байх;

8.2.4. экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, тоог жил тутам 10 хувиар өсгөсөн байх;

8.2.5. холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг төрийн үйлчилгээг нэг цэг, нэг цонх зарчмаар хүргэх ажлыг бүрэн нэвтрүүлсэн өсөлт жил тутам 20 хувиар өссөн байх;

8.2.6. мэдээлэл солилцох цахим тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагын тооны өсөлт жил тутам 20-иос доошгүй хувиар өссөн байх;

8.2.7. төрийн үйлчилгээний шат дамжлага 50 хүртэл хувиар буурсан байх;

8.2.8. аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоо тодорхой хувиар буурсан байх;

8.2.9. Дэлхийн банкны "Бизнес эрхлэх нь" тайлангийн үзүүлэлтэд Монгол Улсын эзлэх байр 2012 онд эхний 50-д, 2013 онд эхний 40-д орсон байх.

Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Стратегид тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо" хэрэгжүүлнэ.

9.2. Орон тооны бус салбар зөвлөлүүд нь энэхүү стратегийн зорилтод тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, материалыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас авч нэгтгэн дүнг "Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо"-нд хагас жил тутамд танилцуулна.

9.3. Орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тус стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зардалд тусгаж байна.

Засгийн газрын 2011 оны 36 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

"ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ"-ИЙН I ҮЕ ШАТ
/2011-2013 ОН/-НД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилт, арга хэмжээ | Хариуцах байгууллага | Хэрэгжүүлэх хугацаа | Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Санхүүжилт (сая төг.) |
|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр | | | | | |
| 1.1 | Хоршооны хөгжлийг дэмжих цогц бодлого боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ | ХХААХҮЯ, МАОЭНХ | 2011-2012 | Төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн, шийдвэрлүүлсэн байна | 1.5 |
| 1.2 | Хөдөө аж ахуйн салбарын тэргүүлэх ач холбогдолтой /мах, ноос, ноолуур, чацаргана, газар тариалан/ кластерыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний саналыг боловсруулж, "Хөдөөгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-тэй уялдуулан боловсруулна | ҮХШХ, ХХААХҮЯ, Өрсөлдөх чадварын судалгааны төв | 2011-2013 | Мах, ноос, ноолуур, газар тариалангийн салбарын кластерыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 3.0 |
| 1.3 | Шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын хоорондын уялдаа холбоог эрчимжүүлж хамтран ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлнэ | БСШУЯ, ҮХШХ, МҮХАҮТ | 2011-2012 | Шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах талаар бодлогын баримт бичиг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 2.0 |
| 1.4 | Гадаад худалдааны хамгаалалтын арга хэмжээний талаар хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх | ГХЯ, СЯ | 2011 | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 2.0 |
| 1.5 | Дестрибьютерийн талаар хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх | ГХЯ | 2011 | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 2.0 |
| 1.6 | Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг | ГХЯ, ҮХШХ, | 2011 | Гадаадын шууд хөрөнгө | 2.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | дэмжих стратеги боловсруулах | ГХОГ | | оруулалтыг дэмжих стратеги боловсруулсан байна | |
| 1.7 | Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой, стандартуудыг шинэчлэх, гадаадын дэвшилтэт стандарт нэвтрүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ | СХЗГ, МХЕГ, МҮХАҮТ, МАОЗНХ | 2011 | Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой, стандартууд шинэчлэгдэн, гадаадын дэвшилтэт стандартыг нэвтрүүлэх талаар авах арга хэмжээний санал, төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна | 10.0 |
| 1.8 | Нэмүү өртөг шингэсэн хувийн хэвшлийн экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратегийг боловсруулна | ХХААХҮЯ, ҮХШХ, СЯ | 2011-2012 | Нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарыг түлхүү дэмжих цогц бодлогыг боловсруулсан байна | 2.0 |
| 1.9 | Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадамжид нийцүүлэн хөдөлмөрийн харилцааны уян хатан зохицуулалтыг дэмжих чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна | НХХЯ, ҮХШХ | 2011 | Холбогдох хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 1.0 |
| Зорилт 2. Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны бодлогоор хөхиүлэн дэмжих чиглэлээр | | | | | |
| 2.1 | "Татварын амралт" (tax vacation) механизмын эрх зүйн орчинг бүрдүүлнэ | СЯ, ТЕГ | 2011-2013 | Татварын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 1.0 |
| 2.2 | Зээлийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулна | СЯ, СЗХ, МҮХАҮТ | 2011-2012 | Зээлийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Даатгалын тухай болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 1.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2.3 | Ноос, ноолуурын экспортын татварыг сэргээх талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна | СЯ, ХХААХҮЯ | 2011 | Холбогдох хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 1.0 |
| 2.4 | Байгаль орчинд халгүй, ногоон эдийн засгийг дэмжсэн үйлдвэрлэл эрхэлж байгаа хувийн хэвшлийн байгууллагыг татвар, зээлийн бодлогоор дэмжих талаар санал боловсруулах | БОАЖЯ, ХХААХҮЯ, СЯ, МҮХАҮТ | 2011-2012 | Тодорхой санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна | 3.0 |
| 2.5 | Алслагдсан аймгийн төв болон сумдад хөрөнгө оруулан ажлын байр бий болгосон ажил олгогчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эсхүл зээлийн дэмжлэг үзүүлэх асуудлаар холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах | СЯ, ХХААХҮЯ, ТЕГ, МАОЭНХ | 2011-2012 | Холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 2.0 |
| 2.6 | Бичил, жижиг, дунд бизнесийг шинээр эхлэж байгаа хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгох талаар санал боловсруулна | СЯ, ТЕГ, ҮХШХ | 2011-2012 | Бичил, жижиг, дунд бизнесийг шинээр эхлэж байгаа хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгох талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 1.0 |
| 2.7 | Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээний шатлал бий болгох талаар санал боловсруулна | СЯ, ТЕГ, ҮХШХ | 2011-2012 | Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээний шатлал бий болгох талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна | 1.0 |
| 2.8 | Улаанбаатар хотын авто замыг шинэчлэн сайжруулах, улсын болон олон улсын чанартай авто замыг шинээр байгуулах тухай цогц арга хэмжээний төлөвлөгөө гарган төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ | ЗТБХБЯ | 2011-2013 | Улаанбаатар хотын авто замыг шинэчлэн сайжруулах, улсын болон олон улсын чанартай авто замыг шинээр байгуулах тухай цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна | 4.0 |
| 2.9 | "Хүнсний бүтээгдэхүүний тээврийн ложистик сүлжээ" дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ | ХХААХҮЯ | 2011 | "Хүнсний бүтээгдэхүүний тээврийн ложистик сүлжээ" дэд хөтөлбөрийг батлуулан, хэрэгжилтийг ханган | 3.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ажилласан байна | |
| 2.10 | Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн альтернатив хувилбар гаргах талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ | СЯ, ХХААХҮЯ, МҮХАҮТ | 2011-2012 | Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн альтернатив хувилбар гаргах талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 1.0 |
| Зорилт 3. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох чиглэлээр: | | | | | |
| 3.1 | Бизнесийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох цахим тогтолцоог бий болгоно | ТШСАА, МШХХТГ | 2011-2012 | Бизнесийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох цахим тогтолцоо бий болж, бизнес эрхлэгчдийн үргүй зардал багассан байна | 15.0 |
| 3.2 | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, хувийн хэвшилд шилжүүлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ | ЗГХЭГ, ХЗДХЯ, ҮХШХ, МҮХАҮТ | 2011-2013 | Тодорхой шалгуурын дагуу төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх жагсаалтыг салбар бүрээр боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 2.0 |
| 3.3 | Төрийн үйлчилгээнд ISO 9001 олон улсын стандартыг нэвтрүүлэхэд төрийн эгээс дэмжиж ажиллана | ЗГХЭГ, ҮХШХ | 2011-2012 | Холбогдох төрийн байгууллагуудад ISO 9001 олон улсын стандартыг нэвтрүүлсэн байна | 1.0 |
| 3.4 | Бараа, үйлчилгээ худалдан авах бүхий л үйл ажиллагаар нээлттэй болгох зорилгоор "Цахим худалдан авалт"-ын (e-procurement) үйл ажиллагаа боловсронгуй болгож, холбогдох төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ | СЯ, МШХХТГ | 2011-2013 | "Цахим худалдан авалт"-ыг (e-procurement) төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна | 5.0 |
| 3.5 | "Бизнес инкубатор" төвүүдээр дамжуулан бизнес эрхлэх үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, тэдгээрийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ | ҮХШХ, МАОЭНХ, МҮХАҮТ | 2011-2012 | Бизнес эрхлэгчдэд бизнесийн холбоотой хууль, эрх зүйн талаар сургалт зохион байгуулсан байна | 10.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.6 | "Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон түншлэл" сэдэвт үндэсний чуулганыг зохион байгуулна | ҮХШХ, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, МҮХАҮТ, МАОЭНХ | 2011 | "Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон түншлэл" сэдэвт үндэсний чуулганыг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна | Олон улсын байгууллага-10.0 Төсөв- 5.0 |
| 3.7 | Үнэт цаасны зах зээлийн хувийн хэвшил болон брокер, дилерийн байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулах | Хөрөнгийн бирж, СЗХ, ТӨХ | 2011-2013 | Үнэт цаасны зах зээлийн хувийн хэвшил болон брокер, дилерийн байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 2.0 |
| 3.8 | Нэг цэгийн үйлчилгээнд бизнес эрхлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичгийн тайлбар өгөх "Бизнес ширээ"-г нэвтрүүлэн үйл ажиллагааг нь жигдрүүлэх | Холбогдох агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ | 2011 -2012 | Нэг цэгийн үйлчилгээнд бизнес эрхлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичгийн тайлбар өгөх "Бизнес ширээ"-г нэвтрүүлэн үйл ажиллагааг нь жигдрүүлсэн байна | 7.0 |
| 3.9 | Компанийн нийгмийн хариуцлагын шалгуур үзүүлэлтийг боловсруулна | ТӨХ, ҮХШХ | 2011 | Компанийн нийгмийн хариуцлагын шалгуур үзүүлэлтийг батлуулсан байна | 1.0 |
| | Зорилт 4. Хувийн хэвшлийн хөгжлийг хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалт, хүний нөөцийн бодлогоор дэмжих чиглэлээр: | | | | |
| 4.1 | Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх чиглэлээр өөрчлөн шинэчлэх асуудлаар яам, шинжлэх ухааны байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ | НХХЯ, ҮХШХ, МАОЭНХ, холбогдох яамд | 2011-2012 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх асуудлаар хөтөлбөр боловсруулсан байна | 3.0 |
| 4.2 | Хувийн хэвшлийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулна | НХХЯ, МАОЭНХ | 2011-2012 | Хувийн хэвшлийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна | 2.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.3 | Хувийн хэвшлийн салбар дахь мэргэжлийн зэрэг дэвийн тогтолцоог шинэчлэх саналыг боловсруулна | НХХЯ, БСШУЯ, МАОЭНХ | 2011 | Хувийн хэвшлийн салбар дахь мэргэжлийн зэрэг дэвийн тогтолцоог шинэчлэн, саналыг боловсруулсан байна | 1.0 |
| 4.4 | Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, хувийн хэвшлийн салбарын удирдлага, ажилтнуудад хууль, санхүү, татварын чиглэлээр давтан сургах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ | ҮХШХ, ХХААХҮЯ, ЖДҮГ, МҮХАҮТ, МАОЭНХ | 2011-2012 | Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн захирал, дунд, дээд шатны менежер, техникийн албан тушаалтныг давтан сургах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна | 5.0 |
| 4.5 | Зохист хөдөлмөрийн төлөө үндэсний хөтөлбөрийг боловсруулна. | НХХЯ, МАОЭНХ, МҮЭ | 2011 | Зохист хөдөлмөрийн төлөө үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байна. | 2.0 |
| 4.6 | Олон улсын ажлын байрны Пактыг Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна | НХХЯ, МАОЭНХ, МҮЭ | 2011 | Олон улсын ажлын байрны Пактыг Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна. | 2.0 |
| 4.7 | Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулна | НХХЯ, ҮХШХ, МАОЭНХ, МҮЭ | 2011-2012 | Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж, шийдвэрлүүлсэн байна | 2.0 |
| 4.8 | Даатгуулагчдад чанартай үйлчилгээ үзүүлэх чадвартай, өөрөө өөрийгөө удирддаг, бие даасан тогтолцоо бүрдүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ | НХХЯ, МАОЭНХ, МҮЭ | 2011-2013 | Даатгалын бие даасан тогтолцоо бүрдүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна | 5.0 |
| | НИЙТ | | | | 123.5 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

**Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2011 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор батлсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг 2011 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 2.632.770 (хоёр сая зургаан зуун гучин хоёр мянга долоон зуун далан) төгрөг байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Л.Болд, Сангийн сайд С.Баярцогт нарт, цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа иргэдийн мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД** **Л.БОЛД**

Засгийн газрын 2011 оны 37 дугаар
тогтоолын хавсралт

### 2011 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

| № | Аймаг, нийслэл | Тооны дээд хязгаар |
|---|---|---|
| 1 | Архангай | 80 |
| 2 | Баян-Өлгий | 80 |
| 3 | Баянхонгор | 55 |
| 4 | Булган | 35 |

| | | |
|---|---|---|
| 5 | Говь-Алтай | 60 |
| 6 | Говьсүмбэр | 10 |
| 7 | Дархан-Уул | 24 |
| 8 | Дорноговь | 20 |
| 9 | Дорнод | 60 |
| 10 | Дундговь | 10 |
| 11 | Завхан | 30 |
| 12 | Орхон | 15 |
| 13 | Өвөрхангай | 50 |
| 14 | Өмнөговь | 40 |
| 15 | Төв | 60 |
| 16 | Увс | 50 |
| 17 | Сүхбаатар | 50 |
| 18 | Сэлэнгэ | 30 |
| 19 | Ховд | 100 |
| 20 | Хөвсгөл | 70 |
| 21 | Хэнтий | 30 |
| 22 | Улаанбаатар | 74 |
| | БҮГД | 1033 |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 38 — Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД** — **Л.БОЛД**

Засгийн газрын 2011 оны 38 дугаар тогтоолын хавсралт

## ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИД НЭГ УДААГИЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

1. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан тэтгэмжийг олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох цалин хөлсөнд дараах цалин, нэмэгдлийг оруулан тооцно:

2.1. Албан тушаалын үндсэн цалин.
2.2. Цэргийн цолны цалин.
2.3. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл.
2.4. Хилийн нэмэгдэл.
2.5. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл.
2.6. Онцгой нөхцөлийн нэмэгдэл.
2.7. Хууль тогтоомжийн дагуу олгосон бусад нэмэгдэл, цалин.

3. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийг олгохдоо сүүлийн 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д хувааж, гарсан дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.

4. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэтгэмжийг мөн хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэнд олгохдоо сүүлийн 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д хувааж, гарсан дундаж цалин хөлсийг 18 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.

5. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "орон тоо зохион байгуулалтын өөрчлөлт" гэдгийг анги, байгууллага нь татан буугдсан, цэргийн албан хаагчийн ажлын байр нь бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр цомхотгогдсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсныг үндэслэнэ.

6. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "биеийн эрүүл мэндээр" гэдгийг эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр гарсныг үндэслэн тогтооно.

7. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэмжийг авах хүсэлт гаргахдаа тухайн цэргийн албан хаагч дараах бичиг баримтыг бүрдүүлж, тухайн

байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтанд өгнө:

7.1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хугацаа сунгасан тухай шийдвэр.

7.2. Нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг урьдчилан авахыг хүссэн хувийн өргөдөл.

7.3. Ажиллаж байгаа анги, байгууллагын удирдлагын тодорхойлолт.

7.4. Албан тушаалын цалингийн тодорхойлолт.

8. Төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 7-д заасан бичиг баримтыг хүлээн аваад тэтгэмж олгоход шаардагдах хөрөнгийг дараа жилийн төсөвт тусган олгох ажлыг зохион байгуулна.

9. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэмжийг авсан иргэн цэргийн тэтгэвэр тогтоолгосны дараа үлдэх хэсгийг авах эрхтэй болно. Ийнхүү олгосон тохиолдолд нийт тэтгэмжийн хэмжээ 36 сараас хэтрэхгүй байна.

10. Тэтгэвэр тогтоолгосон болон халагдсан офицер, ахлагч нар цэргийн албанд дахин ажиллаж байгаад халагдах үед энэхүү журмын 3, 7-д заасан нэг удаагийн тэтгэмж авсан тохиолдолд тэтгэмжийг дахин олгохгүй.

11. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтан тодорхойлно. Цэргийн алба хаасан хугацааг хуанлийн бүтэн жилээр тооцно.

12. Цэргийн албанд ажилласан хугацааг тооцох үндсэн бичиг баримт нь офицер, ахлагчийн хувийн хэрэг, архивын лавлагаа, сүүлийн 5 жилийн цалингийн тодорхойлолт байна. Архивын лавлагаа авах боломжгүй тохиолдолд цэргийн албанд ажилласан хугацааг шүүхээр тогтоолгоно.

13. Цэргийн албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага жил бүр төсөвтөө тусгана.

14. Цэргийн албан хаагчийн ажиллаж байсан анги, байгууллагын захирагч /дарга/, санхүү хариуцсан ажилтнууд энэ журмын дагуу тухайн цэргийн албан хаагчийн цалин хөлсийг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээнэ.

15. Сарын дундаж цалин хөлсийг буруу тодорхойлох, хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэргээр нэг удаагийн тэтгэмжийг буруу тогтоож олгосон албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 02 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 41 | Улаанбаатар хот |

**Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэх тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улс 2011-2013 онд Африк-Азийн бүсэд байгалийн олон төрлийн гамшгийн аюулаас урьдчилан сэрэмжлүүлэх нэгдсэн систем (RIMES) байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсугай.

2. Монгол Улс Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан уг ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт даалгасугай.

3. "Олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай" Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвөөс хандив төлөх олон улсын гэрээ, конвенцийн итгэмжит сангийн жагсаалт"-д дор дурдсан нэмэлт оруулсугай:

"21. Африк-Азийн бүсэд байгалийн олон төрлийн гамшгаас урьдчилан сэрэмжлүүлэх нэгдсэн систем (RIMES) – БОАЖЯ" гэж.

| | |
|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** | **С.БАТБОЛД** |
| **ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД** | **Г.ЗАНДАНШАТАР** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот |

**Аргачлал батлах тухай**

Ашигт малтмалын тухай хуулийн 47.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлал"-ыг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэхүү тогтоолыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

| | |
|---|---|
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** | **С.БАТБОЛД** |
| **САНГИЙН САЙД** | **С.БАЯРЦОГТ** |

Засгийн газрын 2011 оны 48 дугаар
тогтоолын хавсралт

## АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВИЙГ ТООЦОХ, ТӨЛБӨР НОГДУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн эдэлбэр газраас олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулахад энэхүү аргачлалыг баримтална.

Хоёр. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төсөвт төлөх

2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тухайн сард худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан алт, мөнгөнөөс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцохдоо Эрдэс баялаг, эрчим хүчний яамны цахим хуудсанд зарласан ашигт малтмалын бүтээгдэхүүний сарын жишиг үнийг баримтлан Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2, 47.5-д заасныг үндэслэн тооцож, "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 272 дугаар тогтоолын дагуу төсөвт төлнө.

2.2. Дотоодод худалдсан болон экспортод гаргасан алт, мөнгөний борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцохдоо Монголбанкнаас тухайн өдөр зарласан үнийг баримтлан Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2, 47.5-д заасны дагуу тооцож, "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 272 дугаар тогтоолын дагуу төсөвт төлнө.

2.3. Дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Үндэсний статистикийн хорооноос тухайн сард зарласан үнийг баримтлан Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.1-д заасны дагуу тооцож, "Журам батлах тухай" Засгийн газрын 2006 оны 272 дугаар тогтоолын дагуу төсөвт төлнө.

2.4. Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний сарын мэдээг Гаалийн ерөнхий газар гаргаж, дараа сарын 5-ны өдрийн дотор Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Сангийн яам, Татварын ерөнхий газарт

албан бичгээр болон цахим сүлжээгээр хүргүүлж байна.

Гурав. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах, тайлагнах, тооцоо хийх

3.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд улирал бүр тухайн улиралд худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнд ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан гарган, эцсийн тооцоог харъяалах татварын албатай хийнэ.

3.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тухайн улиралд худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан алт, мөнгөнөөс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тооцохдоо Эрдэс баялаг, эрчим хүчний яамны цахим хуудсанд зарласан тухайн улирлын сарын дундаж үнийг баримтлан сар бүр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланд нэгтгэж тусгана.

3.3. Дотоодод худалдсан болон экспортод гаргасан алт, мөнгөний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тооцохдоо энэ аргачлалын 2.2-т заасан үнийг баримтлан өдөр бүр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланд нэгтгэж тусгана.

3.4. Дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тооцохдоо энэ аргачлалын 2.3-т заасан үнийг баримтлан сар бүр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланд тухайн улирлын саруудын дүнг нэгтгэж тусгана.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар өдөр тутам хяналт тавьж ажиллана.

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 2,5
**Индекс: 14003**



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487